Шинэ коронавирусын үед илэрч буй шинж, лабораторийн болон багажийн оношилгоонд тулгуурлаж уламжлалт анагаах ухааны халдварт хижиг өвчний оноштой дүйцүүлэн эмчлэх боломж

С.Сээсрэгдорж[1], С.Ваанчигсүрэн[2], С.Доржбат[3]

[1,3]АШУҮИС. МАУОУС
[2]АШУҮИС. АУС
Цахим хаяг: seesregdorj@mnums.edu.mn, Утас: 99296858

Түлхүүр үг:
Covid-19
Монгол
Анагаах
Оношилгоо
Сонголт

Товч утга:

Үндэслэл: Уламжлалт анагаах ухааны сурвалж, түүний томоохон тайлбарууд, монгол мэргэдийн зарим бүтээлүүдийн хүрээнд шинэ коронавирусын халдварын үед илэрч байгаа шинжүүд, оношилгоонд тулгуурлан харьцуулж дүйлгэн оношлох нь шинэлэг агуулгатайн зэрэгцээ уламжлалт анагаах ухааны эм, эмчилгээ, гам сахих, сэргээх засах их нөөцийг илрүүлэн ашиглах ач холбогдолтой байна. **Зорилго:** Шинэ коронавирусын халдварын үед илэрч байгаа шинж, оношилгоонд тулгуурлан уламжлалтын сурвалж, тайлбар бүтээлүүдийн хижиг өвчний ангилалд хамаарах хоорондоо уялдаа, холбоотой өвчнүүдийн эмгэг жам, шинжүүдтэй харьцуулан шинжлэх. **Хэрэглэгдэхүүн, аргазүй:** ДЭМБ, ХӨСҮТ-ийн тандалтын төвийн болон бусад мэдээлэл, “АУДҮ” сурвалж түүний томоохон тайлбар болох “Манаг лхантав”, монголын мэргэдийн “Рашааны цагаан шүүдэр”, “Увдисын эрдэнэ гарахын орон” бүтээлүүдийг эх хэрэглэгдэхүүн болгож “Эх бичиг, сурвалж судлалын харьцуулах арга”-аар харьцуулан, “Магадлан жагсаах арга”-аар төрөлжүүлэн онцлогийг тодруулж “Нэгтгэн дүгнэх арга”-аар хураангуйлан үнэлж судалгааг хийж гүйцэтгэсэн. **Үр дүн:** Шинэ коронавирусын халдварын үеийн шинж, оношилгоонд шинжлэл хийхэд уламжлалт анагаахын халдварт халуун өвчний эс боловсорсон халууны үе шатыг дамжиж байна. Халдвар заримдаа хурдан хугацаанд боловсрох чөлөөгүй аньсанд буусан хижиг дэлгэрсэн халуунд шилжих эсвэл мөн чанараар үүссэн хямарсан халуун хижиг болж хүндрэх хэлбэрээр эмнэлзүй нь явагдаж байна. Уламжлалт анагаах ухаан өөрийн онол, арга зүйн хүрээнд халдварт хижиг өвчнийг тодорхой таньж мэдэж чаджээ. Шинэ коронавирусын халдварыг уламжлалт оноштой дүйлгэн авч үзвэл хөнгөн үед шууд, хүнд, маш хүнд болон хүндрэлээс урьдчилан сэргийлэхэд орчин үеийн стандарт эмчилгээтэй, уламжлалт эм, заслын аргуудыг хавсруулан эмчлэх их нөөц байна. Монгол мэргэд дүйлгэж байгаа уламжлалт оношийн хүрээнд хачир тавьж хэрэглэх жоруудыг олшруулж ханд болон зүүх, утах, хамарт дусаах эмүүдийг шинээр оруулжээ. **Дүгнэлт:** 1. Шинэ коронавирусын халдварын шинжүүдийг шинээр илрүүлэн бүртгэж мэдээлж байгаа хэдий ч одоохондоо цэгцэрч бүрэн таньж мэдээгүй байгаагийн зэрэгцээ тодорхой үе шатанд төрөлжүүлэн ангилж амжаагүй байна. 2. Шинэ коронавирусын халдварын шинжүүд болон эмнэлзүйн явцыг уламжлалт анагаах ухааны оноштой дүйлгэн хөнгөн үед шууд, хүнд, маш хүнд үед хавсруулан эмчлэх боломжтой байна. 3. Шинэ коронавирусын халдварын үеийн гол хүндрэл болох “Уушгины судасны бүлэн”-г “Судасны цусан бэтэг” уламжлалт оноштой дүйлгэж хүндрэлээс урьдчилан сэргийлэх эм, заслын сонголт өргөн байна.

Үндэслэл: Шинэ коронавирусын халдвар цар тахлын хэмжээнд хүрч дэлхийн аль ч улс хийгээд хэнбугайг ч ялгаварлахгүйгээр халдвар тархаж байна. Аль ч оронд ДЭМБ-аас гаргасан зөвлөмжийн дагуу эмчилгээ хийгдэж ирлээ. Гэхдээ уламжлалт анагаах ухааныг эртнээс эмчилгээндээ хэрэглэдэг өндөр хөгжилтэй азийн зарим орон тухайлбал Хятадад өөрийнхөө уламжлалт эмийг орчин үеийн эмчилгээтэй хавсруулан хэрэглэхийн зэрэгцээ стандарт эмчилгээндээ хятадын уламжлалт эмийг батлуулан хэрэглэж байна.

Бидэнтэй адил уламжлалт анагаах ухааны онол, аргатай БНХАУ-ын ӨМӨЗО-нд шинэ коронавирусын

халдвар бүртгэгдсэн нийт 75 тохиолдолд орчин үеийн эмчилгээний аргуудтай уламжлалт эм, зарим засал эмчилгээг хэрэглэж 74 тохиолдлыг эмчилж эдгэрүүлсэн талаараа мэдээлж байна.

Манайд ч шинэ коронавирусын халдварын үеийн тусламж үйлчилгээнд уламжлалт эмчилгээг өргөн хүрээтэй хэрэглэж эхэллээ. Уламжлалт анагаах ухааны сурвалж, түүний томоохон тайлбарууд Монгол мэргэдийн зарим бүтээлүүдийн хүрээнд шинэ коронавирусын халдварын үед илэрч байгаа шинжүүд, оношилгооны үр дүнг харьцуулахад уламжлалт анагаах ухаанд өвчний эмгэг жам, оношилгоо, өвчний үе шат, явцыг өөрийнхөө онол, аргазүйн хүрээнд нарийвчлан тодорхойлсон байгаагаас санаа, сэдэл авах шинэлэг агуулгатайн зэрэгцээ уламжлалт анагаах ухааны эм, эмчилгээ, гам сахих, өвчний махбодыг сэргээх, төлжүүлэх зорилгоор хэрэглэх ач холбогдол, нөөц их байгааг толилуулах нь зүйтэй хэмээн үзлээ.

Зорилго: Шинэ коронавирусын халдварын үед илэрч байгаа шинж, оношлогоонд тулгуурлан уламжлалтын сурвалж, тайлбар бүтээлүүдийн хижиг өвчний ангилалд хамаарах хоорондоо уялдаа, холбоотой өвчнүүдийн эмнэлзүйн шинжүүдтэй харьцуулан шинжлэх

Зорилт:

1. Шинэ коронавирусын халдварын үеийн шинжүүдийн талаар мэдээлэл цуглуулж ангилах
2. Шинэ коронавирусын халдварын үед илэрч байгаа шинж, оношлогоог уламжлалт анагаах ухааны хижиг өвчин дамжин хүндрэх, үе шат, цаг хугацааны хамааралтай өвчин бууж дамжих орны шинжүүдтэй харьцуулан оношилж, эмчлэх боломжийг тодруулан гаргах
3. Шинэ коронавирусын халдварын үед илэрч байгаа хүндрэлийн шинжүүдийг уламжлалт анагаах ухааны оноштой дүйлгэж урьдчилан сэргийлэх боломжийг тодруулан гаргах.

Материал, арга зүй:

1. ДЭМБ-н мэдээлэл[1], ХӨСҮТ-ийн тандалтын алба, яаралтай тусламжийн тасгийн судалгаа, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Тунлёо, Алшаагийн эмнэлгүүдийн мэдээлэл, Сайт, Scophus-д бүртгэлтэй сэтгүүлүүд[2].
2. “Анагаах ухааны дөрвөн үндэс”[3] ӨМ-ийн үндэстний хэвлэлийн хороо. 2015 он. “Увдисын үндэс”-ний Халуун өвчний анагаах үес. 23-27-р бүлэг хуу. 433-485
3. Дэсрид Санжаажамц. 1691 онд Төвд хэлээр бичсэн. “Манаг лхантав”[4] Халдварт хижгийн бүлгүүд.

Монгол сурвалж:

1. Ишбалжир (XVIII зуун) “Дөрвөн рашаан”[5] Үндэстний хэвлэлийн хороо. 2017 он. Рашааны цагаан шүүдэр. Х.190-223
2. Жамбалчойжиданзанпэринлэй. 1826 онд Дээд Монгол, Гансу мужийн Лаврин хийдэд төвдөөр анх бичсэн. “Анагаах ухааны шастир бүгдийн шимийг нэгэн зүгт хураасан увдисын эрдэнэ гарахын орон хэмээн оршвой”[6]. З.Оргийн орчуулга. УБ. 2018. Халдварт, Нян халдварт өвчнийг анагаах үес. Х. 98, 114.

Дээрх сурвалж, тайлбаруудыг эх хэрэглэгдэхүүн болгож “Эх бичиг, сурвалж судлалын харьцуулах арга”[7,8]-аар харьцуулан, “Магадлан жагсаах арга”[8]-аар төрөлжүүлэн онцлогийг тодруулж “Нэгтгэн дүгнэх арга[9,10]-аар хураангуйлан үнэлж судалгааг хийж гүйцэтгэв.

Үр дүн: Шинэ корона вирусын шинжүүд: Халуурах 98% (37.5°С-ээс дээш 4-өөс дээш хоног үргэлжлэх) ханиах 75%, цэр гарах 28%, цусаар ханиах 5%, булчин өвдөх 44%, толгой өвдөх 8%, суулгах 3% шинжүүд дээр тамирдах, амьсгал давчдах, цөөн тоогоор хамар бөглөрөх, шингэн нус гоожих, хоолой өвдөх, даарамтгай болох, дотор муухайрах, ухаан балартах[2] шинж илрэх болон өвчний эхэн үед халууралт 43.8%, хүндэрсэн үед 88.9%, ханиалгах 67.8%, илэрч амьсгал олшрох 17.8%, хоолой өвдөх 13.9%, дотор муухайрч, бөөлжих 5%, суулгах хам шинж 3.8% дагалдах ба ховор тохиолдолд биеэр жижиг улаан тууралт гардаг байна.[11,12] Түүнчлэн үнэрлэх, амтлах мэдрэхүй буурах 30% (Хөнгөн дунд зэрэгт илүү тохиолдох) илэрч байна. (Английн чих хамар хоолойн эмч нарын холбоо).[2] Хүндээр өвчилсөн үед уушгины үрэвсэл, хүнд цочмог амьсгалын хам шинж, бөөрний дутагдал үүсгэж үхэлд хүргэх аюултай байгааг мэдээлж байна.

Эхний үед манайд зөөвөрлөгдсөн тохиолдлуудыг ажиглахад ихэвчлэн хамар загатнах, битүүрэх, толгой өвдөх, бие сульдаж ядрах, дотор муухайрах, бие арзайх, хоолой өвдөх зэрэг шинж тэмдгүүд илэрсэн. Халуурах нь эхний шинж тэмдэг нь биш, 37, 38 хэм хүрэхтэй үгүйтэй байсан. Монголдоо ирээд цаг агаарын хуурай байдлаас болоод харшил хөдөлсөн юм боловуу хамар битүүрч байсан, толгой бага зэрэг өвдсөн юм боловуу гээд шинж тэмдгээ анзаарахгүй өнгөрөх магадлалтай байсан тухай мэдээлсэн[2].

Мөн шинэ коронавирусын нууц хугацааг 3-7-14-21 хоног, Хурц үе 6-12 хоног, нийтдээ 1-2 сар үргэлжилж байна. Шинж тэмдэг илрээгүй эхний 7 хоногт халдвар маш их тараадаг. Шинж тэмдэг илэрснээс 8-10 хоногт багасаж байна. Халдварын 95% нь -2 +10 градуст тохиолдож байна (баталгаажаагүй). Томуугийн вирусээс 8-10 дахин их мутацид ордог, РНХ агуулсан вирус нь шинж тэмдэггүй удаан явцтай байна. Эхлээд ам, хоолой, уушгинд сүүлдээ 21-23 хоногт өтгөнд илэрч байна. Хүүхдэд шинж илрэхгүй удаан явж байна. Хөнгөн өвдөж байна. Ахиж халдварлах нь 0.2%байна гэсэн мэдээллүүд бий.[2]

Шинэ коронавирусын халдварын хөнгөн үеийн шинжийг уламжлалт халдварт хижгийн “Эс боловсорсон халуун”-ы шинжүүдтэй харьцуулан авч үзэх нь зайлшгүй байна.

Хүснэгт 1. Халдварт халууны эс боловсорсон халуун буюу шинэ коронавирусын хөнгөн хэлбэр

Хугацаа	Эс боловсорсон үеийн ерөнхий шинж	Шинэ коронавирусын шинж
Уламжлалт 3-5-7-9 хоног **Корона 3-7-14-21 хоног**	Хий, бадганы цагуудаар 1. Бие арзайж чичрүүдэс хүрэх 2.Эвшээх, бие хүнд оргиж залхуурах, 3.Суниах, ам гашуун оргих, 4.Толгой, булчин үе мөч дагаж янгинаж өвдөх, 5.Жихүүцэх, дулаан орчинд таатай 6. Таван мэдрэхүй эрхтний мэдрэмж буурах, 7. Хамар битүүрч ус шиг шингэн нус гоожих 6. Зүүд ихсэж зүүдэндээ заримдаа дэмий ярих, сэтгэл санаа тайван биш болно. Судас нь нарийн, хөлбөрөнги, түргэн лугшдаг. Шээс нь нилэнхүйдээ улбар шар булингартай байдаг. Хэл нь нэлэнхүйдээ цайвар өнгөтэй болж дээр нь хийн улаан гүвдрүү давхарлан гарна. Хижигт толгой, нүдний ухархай, үе мөч, гар хөлийн ясаар шөнийн цагт янгинаж шархирч өвдөх нь илүү байдаг.	Булчин өвдөх 44%, толгой өвдөх 8%, хамар бөглөрөх, шингэн нус гоожих, хоолой өвдөх, даарамтгай болох, дотор муухайрах, үнэрлэх, амтлах мэдрэхүй буурах, хамар загатнах, битүүрэх, хоолой өвдөх,
Харьцуулалт	Эс боловсорсон халууны үед илэрдэг шинжүүдийг шинэ корона вирусын халдварын үед илэрч байгаа шинжүүдтэй харьцуулахад ерөнхий илрэх гадар шинжүүд болон цаг хугацааны хамаарлын шинжүүд дүйж байна. Харин бусад үзэх, хүрэлцэх аргуудаар илрэх шинжүүдийг харьцуулах боломжгүй байлаа.	

Хөнгөн үе (early infection): Халууралт 38^{0}C болон түүнээс дээш халуурах, хуурай ханиах, суулгах, огиудас, бөөлжис хүрэх, ядрах, толгой өвдөх, лимфопени, протромбины хугацаа уртсах[15] шинжүүдийг энэ үед хамааруулж үзлээ.

Хөнгөн үеийн рентген шинжилгээнд хэвийн, зарим тохиолдолд доод дэлбэнд жижиг хэмжээний нэвчдэс төст өөрчлөлт байж болно.

Компьютер томографийн шинжилгээнд: 2 талын уушгины доод дэлбэнд субплеврал байрлалтай Ground glass opacification/opacity (GGO) буюу сүүн шилний өөрчлөлт харагдана.

Эс боловсорсон халуун бол эмнэлзүйн хувьд (Хүснэгт 1) хий, шар, бадганы алинтай хавсарсан нь ялгараагүй, хий нь халууныг тамирт нь түгээн тархааж, бадган нь халууны эхийг дарж нэмэгдүүлэхгүй байгаа нойтон мод ноцохоосоо өмнө утаа гарах мэт өвчний хүч нь бүрэлдэж голомтлог байдалд орж амжаагүй гэхдээ халуун нэмэгдэх нь тасраагүй, өвчний цус, тамирын цус хоёр сүү, ус нийлсэн мэт бүх биед тархсан, халдварт халуун өвчний эхний үе шат юм. Энэ үед тухайн хүний биеийн төрөлх өвөрмөц чанар, нас, улирлын хамааралтайгаар тодорхой шинж илрэхгүйгээр удаан явах магадлалтай байдаг. Уламжлалт анагаах ухаанд энэ үеийг боловсруулах зарчмаар эмчлэх ёстойг заагаад үр дүн хир зөв явж байгааг үнэлэх шалгууруудыг тогтоосон байдаг.

Хүснэгт 2. Эс боловсорсон халдварт халууны боловсрох чөлөөгүй аньсанд бууж дэлгэрсэн буюу шинэ коронавирусын хүндэрсэн үе.

Хугацаа	Дэлгэрсэн үеийн ерөнхий шинж	Шинэ коронавирусын хүндэрсэн шинж
Уламжлалт 6-9 хоног **Корона Хурц үе 6-12 хоног**	Бодиттой халуурах, бие хүндрэх, хөлс үнэртэй болох нүдний өнгө шаравтар болох, хэлэнд өнгөр үүсч, уруул, шүдэнд хаг тогтох, их ундаасах, толгой хүчтэй өвдөх, мэдрэл муудах, судас нарийн эрчимтэй түргэн лугших, шээс улаан, үнэр өмхий, язмаг зузаан болох.	Халуурах 98%, ханиах 75%, цэр гарах 28%, цусаар ханиах 5%, ухаан балартах юм. Одоогоор дунд үе гэж үзэж байгаа (pulmonary phase): амьсгал охор болох, хүчилтөрөгчийн дутагдалд орж уушгинд хэвийн бус зураглал олширч, прокальцитонины түвшин алдагдах[15] шинжүүдийг энэ үед хамааруулж байна. Үрэвслийн маркерууд болох CRP, LDH, IL-6, D-dimer, Ferritin, troponin, NT-proBNP үзүүлэлтүүд ихсэнэ.[15]
Харьцуулалт	Уламжлалт анагаах ухаанд заавал энэ үе шатыг дамжих ёсгүй гэж үздэг. Гэхдээ шинэ коронавирусын халдвар боловсрох чөлөөгүй аньсанд буусан эс боловсорсон халуун буюу дэлгэрсэн халуунд хурдан шилжиж байна. Уламжлалт анагаах ухааны дэлгэрсэн үе нь таван цул эрхтэнд илүү буудагтай хамааралтай авч үзвэл шинэ коронавирусын халдвар уушги, бөөр, зүрхэнд бууж дэлгэрдэг нь нотлогдсон байдаг.	

Хүндэрсэн хэлбэрийн үед компьютер томографийн шинжилгээнд бүүдгэр шилний шинж буюу ground-glass opacity (56.4%) хоёр талын уушгинд олон тооны, нэгэн төрлийн бус эмгэг сүүдэржилт (51.8% bilateral patchy shadowing), crazy-paving pattern буюу чулуун шигтгээний шинж илэрнэ. Уламжлалт анагаах ухаанд хижгийн халдварт халуун, ерийн хорын халуун энэ үе шатанд (Хүснэгт 2) маш богино хугацаанд шилждэг тухай заасан байдаг. Энэ үед бадарсан гал шиг цус, шарын хүч туйлдаа хүртэл арвидаж арга, билгийн ёсны бие биеэ хязгаарлах тэнцвэр алдагдаж хязгаарлалтгүй үрэвсэл явагддагийг

цитокины шуургатай адилтгах боломжтой байдаг. Улмаар билгийн хязгаарлалт үгүй болж даваанаас давсан халуун болж үхэлд хүрдэг.

Хүснэгт 3. Мөн чанараар үүссэн хямарсан халуун хижиг буюу шинэ коронавирусын маш хүндэрсэн үе шат

Хугацаа	Шинэ коронавирусын маш хүндэрсэн үе шат	Мөн чанараар үүссэн хямарсан халуун хижиг
Уламжлалт 6-9 хоног **Корона Хурц үе 7-9-12 хоног**	Амьсгалын цочмог дутагдалд-ARDS (амьсгал богиносох, олшрох, арьс цайж, хөхрөх) орно. Үрэвслийн процесс даамжирч (SIRS) амин чухал эрхтэн тухайлбал зүрх судас, цусны эргэлтийн алдагдал, бөөрний цочмог дутагдал үүсэх гэх зэргээр хүндрэл гарч өвчтөн шокд орох ба цаашлаад нас барах эрсдэлтэй.	**Ерөнхий шинж:** Өвчин цулд байвал маш хүчтэй болох. Бие байнга жихүүцэх, хүчтэй хатгуулах, Амьсгал охор, цэр улбар шар, утааны шүүс мэт. **Нян халуун хижиг:** Давшиж хатгуулах, цэр нь улаан өнгөтэй болох, Хэл уруул цайвар шар, мэдрэл хөнгөн, нойр бага, булчингийн голын шар ус босох. **Хурмал хижиг:** Жихүүцэж даардас хүрэх, үесийн голоор өвдөх, толгой өвдөх дэмийрэх.
Онцлог байдал	Энэ үед 7-9 хоногт цулыг бүрхэж илжрүүлнэ. 11 хоногоос хүч нь буурвал эдгэнэ. Хөвгүүн уушги, зүрхэнд буувал хөнөөл их. Хүндрэл: Амьсгал охор цэр нь хоолойдоо хурах, өвчний хувиралт олон аньсанд буусан нь хугацаа өнгөрвөл эдгэхэд бэрх хэмээн уламжлалт анагаах ухаанд анхааруулсан байдаг**.**	

Маш хүнд хэлбэрийн үед компьютер томографийн шинжилгээнд том талбайг хамарсан бүүдгэр шилний шинж, чулуун шигтгээний шинж болон агаар агуулсан гуурсан хоолойн шинж бүхий нэвчдэст өөрчлөлт болон плеврт бага хэмжээний шингэн илрэх болон АЦДХШ: PEEP ≥ 5 см H_2O өөрийн амьсгалтай үед $PaO_2/FiO2 \leq 100$ мм муб. PaO_2 үзэх боломжгүй үеийг тооцож үзлээ. Лабораторийн шинжилгээнд хүнд болон нэн хүнд үеийн сэрэмжлүүлэх үзүүлэлтүүд болох лимфоцитууд давшингуй буурах, цусанд үрэвслийн маркерууд ихсэх, IL-6 ба С-реактив ууараг түргэн өсөх, лактатын түвшин нэмэгдэх, уушгины гэмтэл богино хугацаанд гүнзгийрэхийг дүйцүүлж үзэх ёстой.

Шинэ коронавирусын халдварын хүнд болон нэн хүнд хэлбэртэй дүйлгэн авч үзэх боломжтой “Аньсанд бууж дэлгэрсэн болон мөн чанараар үүссэн хямарсан халуун хижиг”-ийн (Хүснэгт 3) эмчилгээний зарчим, эмчилгээг сурвалж, тайлбаруудад тодорхой өгүүлжээ. Коронавирусын гол хүндрэлийг “Уушгины судасны бүлэн”гэж үзэж байгаа. Үүнийг уламжлалт анагаах ухаанд тунгалаг эс шингэснээс муу цус дэлгэрч уушги, бөөр, өрц, ходоод, хотринхой гэдэсний судлаар дамжиж нэг газарт хуйларч судасны цусан бэтэг үүсдэг хэмээн илрэх ерөнхий болон ялгавартай шинж, эмчилгээний зарчим, эмчилгээ, урьдчилан сэргийлэх талаар заасантай дүйлгэж эмчилгээг хавсруулан хийх боломжтой байна.

Хүснэгт 4. Халдварт хижгийн эмнэлзүйн явцыг уламжлалт анагаах ухаанд тодорхой цаг хугацааны хамааралтай авч үзсэн нь

Бадганы цаг /3 хоног/	Шарын цаг /3 хоног/	Цусны цаг /3 хоног/	Хий, цус харшилдах цаг /3 хоног/
Толгойд халуун бууснаар толгой өвдөх, булчин үесийн голоор өвдөх, жихүүцэн, даардас хүрэх, эвшээх нь олон, бэрхшээн залхуурах, бөөлжих бөгөөд нарны илчийг хүснэ. Боловсруулах цаг.	Халуун нь эрхтэнд буувал эм нь гашуун оргих, хэлний өнгөр ихдэх, шүд уруулд хаг тогтох, хамар хатах, сонсгол муудах, үг яриа нь тодгүй, хүүхэн хараа томрох, шээс улайх бөгөөд судас эрчимтэй.	Цусанд буувал судас хийгээд шээсний халуун нь урьдахаасаа их болно. Хэл хатах, их ундаасах, хөлсний үнэр өмхий, бие хүндрэх болохоор халууныг дайсан мэт нядлах цаг мөн.	Халуун нь цусанд буувал дэмий балай чалчих, дурьдал тодрохгүй, тамир бага, Өвчний хүч их бол амин судсанд алдах, судас живэнги, нүүр харлах, хэл хуурай ширүүн болох, эсвэл солиорох тул нөхөр мэт эелдэг зөөлнөөр засах цаг мөн.

Уламжлалт анагаах ухаанд халдварт хижиг өвчнийг 3, 3 хоногийн үечлэлтэй авч үздэг нь өвчний явцыг илүү нарийвчлалтай хянах бололцоо олгодог бөгөөд эхний бадганы гурав хоног нь эс боловсорсон үе шаттай дараагийн шарын, цусны, хий+цус харшилдах нийт 9 хоног нь өвчин хүндэрсэн, маш хүндэрсэн үе шаттай дүйх ба өвчний шалтгаан аль оронд илүү оршиж байгааг (Хүснэгт 5) заасан нь сонирхолтой байдаг.

Хүснэгт 5. Халдварт хижиг дамжиж, хүндрэх байдал

Хамарт орших үе	Хоолойд орших үе	Уушгинд орших үе
Хамар нь халуун оргих ба загатнаж, хамраас шингэн нус их гоожино.	Эхлээд хоолой, тагнай багалзууураар халуун оргих, дараа нь хамраас ус гоожих, хоолой бачуурах, найтаах нь олон болно.	Эхлээд хоолой нь сөөж, ханиах нь олон, толгой ба ар өврөөр өвдөх цустай цэр гарах, хүрэн манжингийн шүүс мэт болох эцэст өгөртэй цэрээр ханиах бөгөөд уушги архагт шилжих.
Шинэ коронавирус	**Шинэ коронавирус**	**Шинэ коронавирус**
Хамар загатнах, битүүрэх, шингэн нус гоожих, үнэрлэх, мэдрэхүй буурах, хамар битүүрэх,	Хоолой өвдөх, бага халуурах	Халуурах 98%, ханиах 75%, Цэр, гарах 28%, цусаар ханиах 5%,

Уламжлалт анагаахын өвчний явцын 3,3 хоногийн үечлэлтэй холбож үзвэл 13 хоногоос уул, талын завсрын үед шилжиж ясанд буусан тул сүүж бэлхүүс, яс чөмөг өвдөх, тамир бага, нүүр цайвар, толгой дүйрэх, чих шуугих, нойр бага, бие хөлрөх, хоосон огих, үе үе чичрэх, судас хөндий хоосон, шээс улаан, язмаггүй болох, гаднаа халууны хуурамч шинж илрэх ба хийн хувь дийлэнх болж байгаа учраас хүүхэд мэт тэжээж засах цаг гэдгийг анхааруулсан байдаг. Эмчилгээг оновчтой удирдаж эмнэлзүй жам ёсны дагуу үргэлжилбэл заавал энэ үе шатыг дамжих ёсгүй гэж үздэг. Одоогоор энэ үетэй шинэ коронавирусын шинжийг дүйлгэж үзэх боломжгүй байна.

Хэрвээ уул талын завсрын энэ үеийг танин барьж чадаагүй цол цаашид халууны хуурамч шинж бүхий “Хижгийн хоосорсон” халуунд шилжих ба өвчний шинж эмгэг жам, ангилал, оношилгоог өгүүлж хатуу хүчээр засах зарчмаар эмчлэх тухай тодорхой заасан байдаг.

Хэлцэмж: Уламжлалт анагаах ухааны эртний сурвалж “Найман гишүүнт”-д халдварт халуун өвчний шалтгааныг “Хамрын баруун, зүүн нүхний рома, жонма гэх хоёр судалтай холбож судал өвчин үүсгэх тодорхой нөхцөлүүдэд дарагдсанаас болж үүсдэг. Өвчний гол орныг хамар, хоолой, уушги (Хүснэгт 5) гэж ялгасан”[16] болон “Анагаах ухааны дөрвөн үндэс ”-т халдварт халуун өвчнийг “Цусны оронд орших зэс мэт нарийн болоод үл үзэгдэх хорт хорхойгоос үүсэх” ба “үүсгэгч нь орон, цаг, идээ явдлын нөхцөлөөр хямарч биеийн тамирыг идээд өвчин болюу”[3] гэх мэтээр халдварт халуун өвчний шалтгаан болох үүсгэгчийг 8-р зууны дунд үеэс тодорхой дүрсэлж өгүүлжээ.

Шинэ коронавирусын халдварын үеийн шинжүүдийг уламжлалт анагаах ухааны халдварт хижиг өвчний хоорондоо уялдаа бүхий өвчнүүдтэй харьцуулан үзвэл халуун өвчин заавал дамжих ёстой эс боловсорсон халууны үе шатыг дамжиж байгаа нь тодорхой байна. Уламжлалт анагаах ухаанд энэ үеийн эмчилгээг боловсруулах өвөрмөц зарчмаар эмчилж хэрхэн зөв явгдаж байгааг хянах шалгуурыг тодорхойлж гаргасан байдгийг цаашид олон шинжлэх ухааны зааг уулзварт судалж нотолгоожуулбал эмнэлзүйд шинэ зүй тогтол нээж харуулах боломж байна гэж үзэхээр байдаг.

Халдвар заримдаа хурдан хугацаанд боловсрох чөлөөгүй аньсанд буусан хижиг дэлгэрсэн халуунд шилжих эсвэл мөн чанараар үүссэн хямарсан халуун хижиг болж хүндрэх хэлбэрээр эмнэлзүй нь явгдаж байна. Уламжлалт анагаах ухаанд халдварт өвчнийг гурав, гурав хоногийн үечлэлээр аль оронд илүү гүйх, ямар шинж илэрхийг тодорхой бичсэн нь өөрийнхөө онол, арга зүйн хүрээнд халдварт хижгийг тодорхой таньж мэдсэн болохыг илэрхийлдэг.

Шинэ коронавирусын үед илэрч байгаа шинжүүд болон олон талт оношилгооны аргуудаар илэрч байгаа шинжлэлд тулгуурлаж авч үзвэл хүнд хэлбэрийг “Цагаар үүссэн уушгинд буусан нэвчирсэн хижиг дэлгэрсэн халуун+ халууны хүч маш арвидсан”-тай, маш хүнд үеийг “Мөн чанараар үүссэн уушгинд буусан нян, халуун хижгийн нэвчирсэн хэлбэрийн хямарсан халуун + халууны хүч туйлын арвидсан хэлбэртэй дүйлгэж уламжлалт эмчилгээг хавсран хийх боломжтой байна. Дүйлгэн авч үзэж байгаа уламжлалт оношийн хүрээнд эмчилгээ, өвчний сүүлийг таслах, махбодыг тэгшитгэх, сэргээх ялангуяа уушгийг төлжүүлэх эмчилгээг тодорхой заасны зэрэгцээ Монгол мэргэд эдгээр өвчний үед хачир тавьж хэрэглэх жоруудыг олшруулж ханд болон зүүх, утах, хамарт дусаах эмүүдийг шинээр оруулсан байна. Шинэ коронавирусын халдварын үе шаттай дүйлгэн авч үзвэл уламжлалт эмчилгээний зарчим хийгээд эм, заслууд тодорхой байгаа нь орчин үеийн анагаах ухаантай хавсруулан эмчлэх их нөөц байгааг харуулж байна.

Дүгнэлт:

1. Шинэ коронавирусын халдварын шинжүүдийг шинээр илрүүлэн бүртгэж мэдээлж байгаа хэдий ч одоохондоо цэгцэрч бүрэн таньж мэдээгүй байгаагийн зэрэгцээ тодорхой үе шатанд төрөлжүүлэн ангилж амжаагүй байна.
2. Шинэ коронавирусын халдварын шинжүүд болон эмнэлзүйн явцыг уламжлалт анагаах ухааны оноштой дүйлгэж хөнгөн үед шууд, хүнд, маш хүнд үед стандарт эмчилгээтэй хавсруулан эмчлэх боломжтой байна.
3. Шинэ коронавирусын халдварын үеийн гол хүндрэл болох “Уушгины судасны бүлэн”-г “Судасны цусан бэтэг” уламжлалт оноштой дүйлгэж хүндрэлээс урьдчилан сэргийлэх эм, заслын сонголт өргөн байна.

Ном зүй:

1. *ДЭМБ-н мэдээлэл(ЭМЯ-ны мэдээлэл)*
2. *ХӨСҮТ-ийн тандалтын алба, яаралтай тусламжийн тасгийн судалгаа(ЭМЯ-ны мэдээлэл), ӨМӨЗО-ны Тунлёо, Алшаагийн эмнэлэгүүдийн мэдээлэл.(Мэйлээр авав)*

3. "Анагаах ухааны дөрвөн үндэс" Өвөр монголын үндэстний хэвлэлийн хороо. 2015. "Увдисын үндэс"-ний Халуун өвчний анагаах уес. 23-27-р бүлэг. Хуудас.361,371,416.
4. Дэсрид Санжаажамц. 1691 онд Төвд хэлээр бичсэн. Хадмалт "Манаглхантав"
Халдварт хижгийн бүлгүүд. Хуудас 225.
5. Ишбалжир (XVIII зуун) "Дөрвөн рашаан" Үндэстний хэвлэлийн хороо. 2017 он. Рашааны цагаан шүүдэр. Х 190-223
6. Жамбалчойжиданзанпэринлэй. 1826 онд Дээд Монгол, Гансу мужийн Лаврин хийдэд төвөдөөр анх бичсэн. "Анагаах ухааны шастир бүгдийн шимийг нэгэн зүгт хураасан увдисын эрдэнэ гарахын орон хэмээн оршвой". З.Оргийн орчуулга. УБ. 2018.Халдварт болон нян халдварт өвчнийг анагаах ёс. Хуудас. 98, 114.
7. Хандин Хун. Гременевтик сонгодог зохиолуудыг ойлгох болон тайлбарлах нь. Бээжин 2001 он. Дунфан хэвлэлийн газар. х457
8. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны хөгжлийг эх сурвалжийн судалгаагаар тодруулах нь. Анагаахын шинжлэх ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл.УБ; 2005. х.26
9. Варшавчик М.А. Историографическое источниковедение: "Теория, методология, методика" М:1984. Ст 40.
10. Жамьянгарав Д. "Лувсанданзанжанцаны анагаах ухааны талаар туурвисан зарим ховор зохиолуудын харьцуулсан судалгаа. Анагаах ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, 2010. х.30.
11. Wei-jie Guan, Zheng-yi Ni, Yu Hu, Wen-hua Liang, et.al. Clinical Characteristics of Coronavirus Disease 2019 in China. The Lancet: The new England journal of medicine. February 28, 2020. DOI: 10.1056/NEJMoa2002032.
12. Wang YY, Jin YH, Ren XQ, et al. Updating the diagnostic criteria of COVID-19 "suspected case" and "confirmed case" is necessary. Mil Med Res. 2020;7(1):17
13. Jin-jin Zhang, Xiang Dong, Yi-yuan Cao, Ya-dong Yuan, et.al. Clinical characteristics of 140 patients infected with SARS-CoV-2 in Wuhan, China. European Journal of Allergy and Clinical Immunology. 19 February 2020. https://doi.org/10.1111/all.14238
14. Tang YW, Schmitz JE, Persing DH, Stratton CW. The Laboratory Diagnosis of COVID-19 Infection: Current Issues and Challenges. J Clin Microbiol. 2020
15. Hasan K. Siddiqi, Mandeep R. Mehra. COVID-19 Illness in Native and Immunosuppressed States: A Clinical-Therapeutic Staging Proposal. The journal of Heart and Lung transplantation. 2020.03.12. DOI: https://doi.org/10.1016/j.healun.2020.03.012
16. Ловонбаво. "Найман гишүүнтийн зүрхний хураасан судар оршивой". Эмхэтгэсэн Ма Мин. ӨМ-ын ардын хэвлэлийн хороо, 2016. Хуудас 317, 334

Comparative analysis between symptoms and diagnosis of the new coronavirus infection and characteristics of the infectious diseases of traditional medicine

Seesregdorj S[1], Vaanchigsvren S[2], Dorjbat S[3]

[1,3]International school of Mongolian medicine, MNUMS
[2]School of medicine, MNUMS
Email: seesregdorj@mnums.edu.mn, Tel: 99296858

Introduction: Clarifying comparative analysis upon symptoms and diagnosis during the new coronavirus disease by associating with sources of traditional medicine and their major commentaries is essential. That indicates its innovative approach for discovering traditional medicine, treatment methods, and observing a strict regime in illness based on traditional ways of treating diseases.

Aim: To compare symptoms and diagnosis during the new coronavirus disease with pathological symptoms of infectious diseases according to sources of traditional medicine and their significant commentaries.

Materials and methods: A Sources have based on WHO information, the Surveillance centre of the National Center of Communicable Diseases, other sources, "Four Medical Tantras" and its explanation sources such as "Managlkhantav", "Rashaanii tsagaan shuuder", "Uvidasiin erdene garakhiin oron" kinds of literature. Data analysis carried out by reference comparative, probability sample and listing methods.

Results: A result showed that coronavirus infection symptoms might have related to unripened hot disease in traditional medicine. However, in some cases, the condition is very quickly spread, indicating hot infectious disorder and disturbs hot mess, which means aggravation of symptoms. According to traditional medicine and its theory, the hot contagious disease has been widely documented and explained. Comparison between the new coronavirus infection and traditional medicine, there are resources in a combination of modern and traditional medicine, therapy to prevent a mild, moderate, severe condition.

Conclusion:

1. Although new coronavirus infection characteristics are discovered and confirmed, it is yet to completely identify and categorize at certain stages.
2. It is possible to compare characteristics and clinical process of new coronavirus infections and traditional medical diagnosis and combine with treatment on mild, moderate, and severe stage.
3. "Pulmonary vascular clot", which is the new coronavirus's primary severe condition, might compare to a like vascular tumour traditional diagnosis. The choice of drugs and treatments can appropriate in traditional medicine to prevent severely phase

Keywords: Covid-19, Mongol, medicine, diagnosis, choice